



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/126/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.03.15 № 258
танай _____ ны № _____ т

“ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН
ИРЭЭДҮЙ” ХХК-НИЙ ЗАХИРАЛ
Ш.ӨЛЗИЙХУТАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг байдал буруу илэрхийлэлтэй байна. Үүнд:

- ✓ 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Орхон аймгийн “Хантүм глобал” ХХК дэлгүүрээс оффисын ширээ сандал, шкаф худалдан авч зарцуулахдаа шаардах хуудасгүй хөрөнгө гаргах захирлын тушаал шийдвэргүй гаргасан.
- ✓ Төл сонгино үрлэгчийг Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор шууд худалдан авалт хийсэн нь хаана ашиглах зориулалтаар авсан нь тодорхойгүй худалдан авалт хийсэн.
- ✓ “Хөдөө аж ахуйн ажилтан”-ны өдрийг тохиолдуулан салбарын ажилчдын дунд туршлага судлах зорилгоор Булган, Хангал сум, Хялганат тосгонд зохион байгуулахад “ХААХИ” ХХК-ий дотоод журмын 9.1.1.10 дахь заалтыг үндэслэж 1,200,000.00 төгрөгийг үйл ажиллагааны зардлаас гаргасан.
- ✓ 2021 оны 10 сараас 12 сарын хугацаанд Гурванбулаг, Хялганат, Хангал, Хутаг-Өндөр сумдад ажиллахаар нийт 1,196,630.00 төгрөгийн шатахуун зарцуулсан боловч ямар ажлаар тус сумдад ажилласан нь тодорхойгүй.

D:/bichighereg/2022A4toot

006020338

- ✓ Ланд 100 маркийн суудлын авто машиныг 59,950,000.00 төгрөгөөр түрээсийн орлого буюу үндсэн данснаас худалдан авалт хийсэн зөрчлүүд нь батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А			
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1315244784.56	822981597.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10845823.53	25563251.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,845,823.53	25,563,251.47
3121	Төгрөг	10845823.53	25563251.47
31213	Арилжааны банк дахь харилцах	10,845,823.53	25,563,251.47
33	АВЛАГА	1,259,066,261.03	795,919,239.97
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,259,066,261.03	795,919,239.97
35	БАРАА МАТЕРИАЛ	45332700.00	1499106.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	124,900.00	117,100.00
354	Хангамжийн материал	7800.00	1382006.00
35410	Бичиг хэргийн материал	7,800.00	77,600.00
35420	Аж ахуйн материал	00.00	905,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	399,406.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2077011709.26	3314395375.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2077011709.26	3314395375.84
392	Биет хөрөнгө	2076131709.26	3313662042.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	123,180,060.00	123,180,060.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,814,051.83	-13,970,122.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,000,000.00	59,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,665,277.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,172,300,000.00	1,576,609,904.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,213,472.26	-311,857,455.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,000.00	3,661,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,500.01	-87,406.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	885,881,340.00	1,887,351,340.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	-266,666.64	-9,510,000.01
393	Биет бус хөрөнгө	880000.00	733333.33
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-146,666.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3392256493.82	4137376973.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	450885.60	19950000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	450885.60	19950000.00
413	Өглөг	450885.60	19950000.00
4136	Бусад өглөг	450885.60	19950000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	00.00	19,950,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3391805608.22	4117426973.28
51	Засгийн газрын хувь оролцоо	3391805608.22	4117426973.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2226361400.00	2226361400.00
51101	Өмч: - төрийн	2,226,361,400.00	2,226,361,400.00
512	Хуримтлагдсан үр дүн	1165444208.22	1891065573.28
51210	Өмнөх үеийн үр дүн	1,165,444,208.22	1,165,444,208.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	725,621,365.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3392256493.82	4137376973.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1888607342.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1888607342.51
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1888607342.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1619209001.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,239,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,610,970,001.51
120005	Түрээсийн орлого	00.00	150,398,340.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	00.00	119,000,001.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	1057215977.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1057215977.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1057215977.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	53102596.35
210101	Үндсэн цалин	00.00	53,102,596.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	6509336.11
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	6,509,336.11
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	11906139.00
210401	Бичиг хэрэг	00.00	860,396.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	210,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	5,727,240.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	5,108,503.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	4519500.00
210604	Урсгал засвар	00.00	4,519,500.00
2107	Томилот, зочны зардал	0.00	2026500.00
210702	Дотоод албан томилот	00.00	2,026,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	633175.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	159,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	61,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	412,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	978518730.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	739,694,493.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,533,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	237,291,237.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	831391365.12
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	19369999.96
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	19,369,999.96
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	125140000.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	125,140,000.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-105770000.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	725621365.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн

C0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-74,778,997.81	3,466,584,606.03	3,391,805,608.22
C0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-74,778,997.81	3,466,584,606.03	3,391,805,608.22
C0 8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-74,778,997.81	3,466,584,606.03	3,391,805,608.22
D0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-74,778,997.81	3,466,584,606.03	3,391,805,608.22
D0 8	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	725,621,365.06	00.00	725,621,365.06
D0 9	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	650,842,367.25	3,466,584,606.03	4,117,426,973.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	141354870.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	141354870.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	141354870.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	00.00	141,354,870.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	84056576.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	84056576.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	84056576.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	51817851.52
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	51,817,851.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	8041115.61
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	8,041,115.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	147840.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	147,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	13490509.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	9,590,409.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	00.00	3,900,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	10559260.60
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	511,885.60
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	00.00	159,675.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	00.00	9,887,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	57298293.27
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	19000000.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	00.00	19,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	61162900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	61162900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	61162900.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	61,074,900.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	88,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-42162900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	15135393.27
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	10,845,823.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	25,563,251.47

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК нь “Засгийн газар болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс нийлүүлэгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, бэлчээрийн даац хомсдож, мал эрчимтэй өссөнтэй холбоотойгоор хадлан бэлтгэх, малын тэжээл үйлдвэрлэх, төрөл бүрийн үр, бордоо нийлүүлэх, худалдаалах байдлаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, эрсдэл даах үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, үүссэн хуримтлалаар инновацад түшиглэсэн хөрөнгө оруулалт, технологийг хөгжүүлэх бизнес үйл ажиллагаа эрхлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, борлуулалтыг дэмжих.
- ✓ Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг байгуулах, таримлын нэр төрлийг олшруулах, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх.
- ✓ Хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах.
- ✓ Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах.
- ✓ Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, ногоон тэжээл тариалах, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд ээлтэй, усалгааны дэвшилттэй технологи нэвтрүүлэх.
- ✓ Үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах.
- ✓ Мал сүргийн бүтэц, сүргийн чанарыг сайжруулж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ашиглаж удмын санг хамгаалахын зэрэгцээ мал сүргийг байгалийн гамшгаас сэргийлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
- ✓ Өрхийн орлого санхүүг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр хоршиж ажиллаж, тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.

- ✓ Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, бордох, усжуулах, тарималжуулах арга хэмжээг өргөжүүлэн, уст цэгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах
- ✓ Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг байгуулах.
- ✓ Аймгийн цөм сүргийг өсгөн үржүүлж, малын үүлдэр угсааг сайжруулах
- ✓ Хүнсний нарийн ногооны үр, бордоо нийлүүлэх, борлуулах
- ✓ Хөдөө аж ахуй, газар тариаланд шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэх
- ✓ Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх гэсэн 14 зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орж байгууллагын нэрийг Шинэ хөдөө-Хөгжил” ОНӨААТҮГ байсныг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК болгож өөрчилснөөр компаний дүрэм, дотоод журмыг шинэчлэн баталж өөрчилсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 1356886.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13568.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9498.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ХХК нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал” 2008 оны Сангийн сайдын “Тушаалд хэлтэст өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримталсан. Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	1259066.3	795919.2	463147.02
Бараа материал	45332.7	1499.1	43833.6
Үндсэн хөрөнгө	2183327.4	3651632.3	-1468304.9
Нийт хөрөнгө	3392256.5	4137376.9	-745120.5
Өглөг	450.8	19950.0	-19499.1
Хуримтлагдсан үр дүн	0	4117426.9	-158894.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3391805.6	4137376.9	5971.02

Авлага: Тайлант онд болон өмнөх оны үлдэгдэл 1259066.3 мянган төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгөнөөс авах авлага, эцсийн үлдэгдэл 795919.2 мянган төгрөгийн авлагатай тайлант онд 463147.02 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Бараа материал: Оны эхний үлдэгдэл 45332.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1499.1 мянган төгрөг болж өмнөх оноос 43833.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 130377.4 мянган төгрөгийн хангамжийн материал, аж ахуйн материал худалдан авч 174211.0 мянган төгрөгөөр хасагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2183327.4 мянга, эцсийн үлдэгдэл 3651632.3 мянган төгрөг болж өмнөх оноос 1468304.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үндсэн данснаас 1572804.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд 1000.0 мянган төгрөгийн УАЗ 469 маркийн 12-03 БУЛ улсын дугаартай авто машиныг акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байна.

Өр төлбөр: Өглөгийн дансанд оны эхний үлдэгдэл 450.8 мянган төгрөг бол эцсийн үлдэгдэл 19950.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

“Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК нь 2021 онд хүлэмж, арьс нэхий элдэх төхөөрөмж, трактор, агрегат, зөгийн бүл, чацаргана, хонины ноос хяргах төхөөрөмж, жимс хүнсний ногоо хатаагч зэргээс нийт 148328.5 мянган төгрөгийн түрээсийн орлого орж ирэхээр санхүүжилтийг төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

“Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК нь 2021 он үндсэн үйл ажиллагааны данснаас нийт 141354.8 мянган төгрөгийн санхүүжилт буюу орлого орж гүйцэтгэлээр 84640.6 мянган төгрөгийг зарцуулж оны эцсийн байдлаар дансны үлдэгдэл 25563.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Түрээсийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

“Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК нь нэмэлт данс байхгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид цар тахлын улмаас Онцгой комиссын шийдвэрийн дагуу Түлүүгийн давааны ХАА-н гаралтай борлуулах цэгийг түрээслэх хугацааг хойшлуулж 07 дугаар сарын 09-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хойшлуулж, ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор ажилчдад 460.0 мянган төгрөгийн С, Д витаминаар хангаснаас гадна аймгийн онцгой комиссын штабт ажиллаж байгаа онцгой байдал, цагдаа, эмнэлгийн алба хаагчдад нэг удаа 200,000 төгрөгийн хоол, хүнсний тусламж үзүүлжээ.

“Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК нь суурин компьютер 1 ширхэг болон notebook 2 ширхэг нийт 7610.0 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө буюу түрээсийн гэрээгээр эргэн төлөлтөөр авах 795919.2 мянган төгрөгийн авлага, татварт төлөх оны эхний 450.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж, тайлант онд авто машины үлдэгдэл төлбөр болох 19950.0 мянган төгрөг нэмэгдэж санхүүгийн тайланд өглөгтэй тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Улсын төсвөөс батлагдсан 60000.0 мянган төгрөгөөр суудлын автомашин авах асуудлыг ОНӨГ-тай хамтран шийдвэрлэж авто машиныг худалдан авахаар 2 удаагийн тендер зарлаж ажилласан боловч үний санал ирүүлээгүй тул аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн А/421 дугаартай захирамжаар 60000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгож 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 40/21 дугаартай худалдан авах гэрээ байгуулсан байна. Албан хэрэгцээнд суудлын автомашин худалдан авах техникийн тодорхойлолтоор үйлдвэрлэгдсэн оныг 2007 оноос хойш гэж тодорхойлсон боловч 2006 онд үйлдвэрлэгдсэн авто машин худалдан авсан боловч Улсын төсвөөс батлагдсан 60000.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирээгүй, үйл ажиллагааны данснаас 59950.0 мянган төгрөгийг гаргаж машины төлбөрийг төлсөн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Дотоод хяналтын баг бүрэлдэхүүн томилоогүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу “Хөдөө аж ахуйн-Хөгжлийн ирээдүй” ХХК нь нийт 148 мэдээлэл оруулахаас 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж 136 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 29 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн данснаас зориулалт бус зарцуулалт, хэрэгцээ шаардлагад нийцсэн худалдан авалт хийсэн эсэх, тээвэр шатахууны зарцуулалт, туршлага судлах арга хэмжээ, томилолт зэргийг тус бүр авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75342.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс эд хогшил, тээвэр шатахуун, авто машин, бусад зардал, шилэн данстай холбоотой 65525.0 мянган төгрөгийн 8 албан шаардлага, томилолт, үйл ажиллагааны зардал, бусад зардалтай холбоотой 908.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 8910.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа зөрчилгүй.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 2021 оны 03 дугаар сарын 1, 03 дугаар сарын 04-ний өдөр 3 хоног томилолтоор Ш.Өлзийхутаг нь УБ хот руу явсан боловч удирдамж, хөтөлбөргүй бичиггүй, зорилго тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

4.2.2 "Хөдөө аж ахуйн ажилтан"-ны өдрийг тохиолдуулан салбарын ажилчдын дунд туршлага судлах зорилгоор Булган, Хангал сум, Хялганат тосгонд зохион байгуулахад "ХААХИ" ХХК-ий дотоод журмын 9.1.1.10 дахь заалтыг үндэслэж 1200.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаас гаргасан нь дотоод журмыг зөрчсөн мөн Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.5 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

4.2.3 Өмнөх оны өвс хадлагын ажилд хүнсэнд 1 хонь авч хэрэглээд үнийг төлөөгүй, тайлант онд өглөгөөр тусгаагүй, хонины үнийг тайлант онд төлсөн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

4.3 Албан шаардлага

4.3.1 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Орхон аймгийн "Хантүм глобал" ХХК дэлгүүрээс оффисын ширээ сандал, шкаф худалдан авч зарцуулахдаа шаардах хуудасгүй хөрөнгө гаргах захирлын тушаал шийдвэргүй байгаа нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.5 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.2 "ХААХИ" ХХК нь 11 ширхэг ажлын хувцас захилгаар хийлгэсэн нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.5 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.3 Масло, тап, тоормосны шингэнийг 115.1 мянган төгрөгөөр НИК ШТС-аас авсан боловч юунд зарцуулсан нь тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.4 Хээлтүүлэгч малын өмнөх оны гэрээг дүгнэх, хээлтүүлэгч малын түрээсийн гэрээ хийх зорилгоор 8 суманд ажиллахаар 200.0 мянган төгрөгийн талноор шатахуун авсан боловч автомашины зарцуулсан шатахууны замын хуудасгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.5 2021 оны 10 сараас 12 сарын хугацаанд Гурванбулаг, Хялганат, Хангал, Хутаг-Өндөр сумдад ажиллахаар нийт 1196.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч ямар ажлаар тус сумдад ажилласан нь тодорхойгүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.6 Ланд 100 маркийн суудлын авто машиныг 59950.0 мянган төгрөгөөр түрээсийн орлогоор худалдан авалт хийсэн нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.7 Хөвсгөл аймгийн ХХААГ-аас туршлага судлах, хэрэгжиж байгаа ажилтай танилцахаар томилолтоор ажилласан нийт 17 хүн ирж 323.0 мянган төгрөгийн хоол хүнсэнд хөрөнгө гаргах тушаал шийдвэргүй гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.3.8 Нийт 148 мэдээлэл оруулахаас 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлж 136 мэдээг хугацаанд нь оруулсан байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эд хогшилтой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

РС mall дэлгүүрээс 3-н үйлдэлтэй EB-принтерийн худалдан авсан боловч НӨАТ-ын баримт, шаардах хуудасгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2. Эд хогшилтой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Төл сонгино үрлэгчийг Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор шууд худалдан авалт хийсэн нь хаана ашиглах зориулалтаар авсан нь тодорхойгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

3. Шуудан холбооны зардалтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

М.Лхагванямын 99847620 дугаарын төлбөрийг 3, 4, 5, 6 сард сарын 30.0 мянган төгрөгийн төлбөр хийсэн боловч НӨАТ-ын баримтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд зөвлөмж өгөөгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 03 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	“ХААХИ” ХХК	14	75342.6	0	0	3	908.0	8	65525.0	3	8910.0